

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2026 оны 06 дугаар сарын 29-ний өдөр, Даваа гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:	1-4
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	5-13

1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай/	5-7
2.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд хүргүүлнэ./	7-10
3.Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд / Засгийн газар 2026.06.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	11-13

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны
06 дугаар сарын 29-ний өдөр /Даваа гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Б.Заяабал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 53.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 59 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Ш.Бямбасүрэн, М.Энхцэцэг;
Чөлөөтэй: Г.Очирбат, Р.Сэддорж, Б.Уянга, С.Цэнгүүн;
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Ганбаатар;
Тасалсан: Ц.Баатархүү, Ч.Лодойсамбуу, З.Мэндсайхан, О.Цогтгэрэл.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх, референт Т.Билэг-Өрнөх, Х.Шижирмөнх нар байлцав.

Байнгын хорооны дарга Б.Заяабал тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалангийн тавьсан асуултад Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн хариулж, тайлбар хийв.

Б.Заяабал: “Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 1
Бүгд: 21
95.2 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 14 цаг 19 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, **анхны хэлэлцүүлэг**, санал, дүгнэлтээ Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд хүргүүлнэ./

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх, референт Т.Билэг-Өрнөх, Х.Шижирмөнх, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны зөвлөх Бад.Баярмаа, референт Б.Бадралт нар байлцав.

Төсөл санаачлагчийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Анарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, М.Мандхай нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд / Засгийн газар 2026.06.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, **анхны хэлэлцүүлэг**/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Ч.Хишигдалай, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ, мөн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Төгөлдөр, Ашигт малтмал, газрын тосны газрын Газрын тосны ашиглалтын хэлтсийн дарга Ш.Маргад, Татварын ерөнхий газрын Том татвар төлөгчийн газрын дарга С.Төгсжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх, Б.Нарангэрэл, референт М.Мандхай нар байлцав.

Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Б.Заяабал: 1.Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, Ш.Бямбасүрэн, Л.Соронзонболд, Р.Сэддорж нарын гаргасан, Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлийн “5 хувиар” гэснийг “7.5 хувиар” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд үг хэлэв.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 7
Бүгд: 21
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 38 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 39 минут үргэлжилж, 32 гишүүнээс 21 гишүүн хүрэлцэн ирж, 65.6 хувийн ирцтэйгээр 14 цаг 38 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.ЗАЯАБАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 06 дугаар сарын 29-ний өдөр,
Даваа гараг
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим
13 цаг 59 минут.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Заяабал: Эдийн засгийн байнгын хорооныхоо эрхэм гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Хуралдаанд ирсэн гишүүдийг танилцуулъя. Чинбаатарын Анар гишүүн, Отгоншарын Батнайрамдал, Нацагдоржийн Батсүмбэрэл, Пүрэвийн Батчимэг, Хүрэлбаатарын Булгантуяа, Болдын Жавхлан, Батжаргалын Заяабал, Жаргалсайханы Золжаргал, Ганзоригийн Лувсанжамц, Баатаржавын Мөнхсоёл, Эрдэнэбилэгийн Одбаяр, Бадамдоржийн Пунсалмаа, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Агваанлуvsангийн Ундраа, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, Сүхбаатарын Эрдэнэбат, Доржсүрэнгийн Үүрийнтуяа гэсэн гишүүд ирцэд хүрэлцэн ирсэн байна. Ингээд 53.1 хувийн саналаар хуралдааны ирц бүрдсэн тул хуралдаан эхэлснийг мэдэгдье.

Байнгын хорооны хурлаас 53.1 хувь хүрч, Эдийн засгийн байнгын хорооны хорооны 2026 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Өнөөдрийн хуралд бас чөлөөтэй байгаа гишүүд, өвчтэй байгаа гишүүд байгаа юм байна. Чөлөөтэй байгаа гишүүд Энхцэцэг, Бямбасүрэн, Очирбат, Цэнгүүн, Уянга гишүүд чөлөөтэй байгаа. Эмнэлгийн чөлөөтэй Ганбаатар гишүүн байгаа юм байна.

Хуралдаанд ирцэд орсон эрхэм гишүүдийгээ хуралдааны танхимд хүрэлцэн ирэхийг хүсье. Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар бас хэлэлцэх асуудлуудыг танилцуулъя.

Эхний асуудал, Нэр дэвшигчийн сонсголын товыг хойшлуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэх байгаа.

Хоёрдугаарт нь Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулахаар байгаа.

Гуравд нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг мөн явуулахаар байгаа. Ийм 3 асуудлыг хэлэлцэхээр байгаа.

Ингээд хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байвал нэрээ өгөхийг хүсье.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байхгүй байна. Хэлэлцэх асуудлыг хэлэлцэх дарааллаар хэлэлцэхээр шийдвэрлэлээ. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё. Бүгдээрээ хэлэлцэх асуудал руугаа оръё.

Хэлэлцэх асуудал эхний асуудал руугаа оръё.

“Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох тухай” Байнгын хорооны тогтоолыг хэлэлцэж эхэлье.

Тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа. Ингээд тогтоолын төслийг уншъя. Найруулгын хувьд бас засвар сая орсон байгаа. Ингээд “Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох тухай”.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 121 дүгээр зүйлийн 121.3, 121.4 дэх хэсгийг тус тус үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос тогтоох нь:

1.Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 4 дүгээр тогтоолд заасан Монгол банкны Тэргүүн дэд ерөнхийлөгчид нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын төвийг товыг 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулахаар тогтоосугай.

2.Нэр дэвшигчийн сонсголын товыг нийтэд зарлах, сонсголын бэлтгэл хангах ажлыг холбогдох хууль, журамд заасны дагуу зохион байгуулахыг Эдийн засгийн байнгын хороонд даалгасугай гэсэн ийм тогтоолын төсөл байна.

Ингээд тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү.

Жаргалан гишүүн. Жавхлан гишүүнээр тасаллаа. Жаргалан гишүүний микрофоныг олгоё.

Б.Жаргалан: Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Улсын Их Хурлын хаврын чуулган энэ долоо хоногт хаах гээд өдөр болгон чуулганы нэгдсэн хуралдаантай байгаа. Бас хэд хэдэн томоохон хуулийн төсөл хэлэлцэж байгаа. Энэ завсраар болохлоор бас нөгөө наадам дөхүүлээд хэд хэдэн маш чухал байгууллагын томилгооны асуудал энэ олон нийтийн анхаарлын төвөөс бас гадуур яваад байна. Тэгээд заавал Их Хурал нөгөө юу мундсан гэдэг шиг цаг хугацаа мундсан гэдэг шиг энэ наадам дөхчихсөн хаврын чуулганахаа сүүлийнхээ долоо хоногт ийм олон томилгоо хийх нь чухал юм уу?

Өнөөдөр манай дээр энэ Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийн томилгоо яригдаж байна Эдийн засгийн байнгын хороон дээр. Төрийн байгуулалтын байнгын хороон дээр болохлоор Сонгуулийн ерөнхий хороо, мөн Монголын үндэсний олон нийтийн радио,телевиз. Тэгэхээр энэ нөгөө нэр дэвшигчдийн сонсгол хийх явдал чинь болохлоор бас олон нийтэд мэдээлэл өгөх, энэ тодорхой албан тушаал дээр нэр дэвшиж байгаа энэ томилогдох гэж байгаа хүмүүсээс бас асуулт хариулт авах. Үүнд бас гишүүд ач холбогдол өгөх, олон нийтэд нийгэмд бас ач холбогдол өгөх ийм давуу талтай. Тийм ч учраас нэр дэвшигчийн сонсгол хийхээр бас энэ хуульд тусгасан байдаг.

Тэгэхээр бид нар бол яг энэний ач холбогдлыг нь бол байхгүй болгоод байгаа юм шиг санагдаж байгаа. Тухайлсан энэ яг Эдийн засгийн байнгын хороон дээр явах нэр дэвшигчийн сонсголотой холбоотойгоор анх бол энэ нэр дэвшигчийн

сонсголыг 06 дугаар сарын 23-ны өдөр товлосон байсан. Харамсалтай нь 06 дугаар сарын 23-ны өдөр Байнгын хорооны ирц бүрдээгүй, түүний улмаас бол энэ 23-ндаа товлосон цаг хугацаандаа бол сонсгол хийгдэж амжаагүй. Тэгээд энэ нэр дэвшигчийн сонсголыг хийх дэг нь болохлоор Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 121 дүгээр зүйлээр зохицуулагдаж байгаа гэж ойлгож байгаа.

Тэгээд энэ 121 дүгээр зүйл дээр болохлоор хэрэв жишээлбэл сонсголыг хойшлуулах юм бол бас тодорхой шалтгаан, бас тодорхой дэгтэй байгаа. Тэгэхээр яг ямар дэгийн дагуу энэ сонсголыг хойшлуулаад маргааш болгож өөрчилж байна гэдэг нэгдүгээр асуултыг энэ Их Хурлын Тамгын газраас асууя. Яагаад вэ гэхлээр 23-ны өдөр сонсгол ирц бүрдээгүйн улмаас хийгдээгүй. Тэгээд энэ саяын 121 дүгээр зүйлийн яг ямар зохицуулалтаар энэ сонсголын тов хойшлуулах тухай энэ тогтоолыг баталж байна вэ? Энэ Улсын Их Хурал бас ингээд дэгээ зөрчөөд байгаа юм биш биз дээ гэдэг болгоомжлол байна. Тэгэхээр Тамгын газраас хариулт авъя.

Б.Заяабал: Эдийн засгийн байнгын хорооны ахлах зөвлөх Мягмарцэрэн яг энэ дэгтэй холбоотой тодорхой хариулт өгье.

Д.Мягмарцэрэн: Энэ өдрийн мэндийг хүргэе. Дэгийн тухай хуулийн 121.3 дээр энэ хуулийн 119.1-д заасан этгээд сонсголын товыг хойшлуулах шаардлагатай гэж үзсэн бол хойшлуулах шалтгаан, хугацааг тодорхой дурдсан хүсэлтийг энэ хуулийн 121.1-д заасан Байнгын, дэд хороонд ирүүлнэ гэсний дагуу Улсын Их Хурлын 16 гишүүн сонсголын товоо хойшлуулах тухай хүсэлтээ Байнгын хороонд ирүүлсэн байгаа. Энэ дагуу тэгээд сонсголын товыг зарлаж байгаа юм. Багтаж байгаа 29 гэдэг нь.

Б.Заяабал: Жаргалан гишүүнд энэ нэмэлт микрофон өгье. Нэмэлт тодруулга.

Б.Жаргалан: Хэрэв тэр энэ 119 дүгээр зүйлд заасны дагуу тодорхой гишүүдийн хүсэлтээр товыг хойшлуулах шаардлагаар хойшлуулж байгаа тогтоол гарч байгаа бол энэ үндэслэх хэсэгтээ, тогтоолын үндэслэх хэсэгтээ бас тэр хүсэлтээ дурдах байсан уу үгүй байсан уу гэдэг нэгдүгээр асуулт байна. Яагаад гэхлээр энэ үндэслэх хэсэгт нь бол тэр гишүүдийн хүсэлтийг бол огт дурдаагүй байна. Тэгээд тэр гишүүдийн хүсэлтээ бас бид нар тарааж өгөх байсан уу үгүй байсан уу? Тэгэхээр бид нарт ер нь бол цаашдаа энэ нөгөө дэгээ манай Байнгын хороо бас маш сайн сахимаар байна.

Тэгээд маргааш өглөө 9 цагаас гэж зарлаж байгаа юм байна? Өнөөдөр бол үдээс хойш болчихсон байж байна. Тэгээд 14 цаг хамгийн гол нь энд гишүүд өөрсдөө бэлтгэл сайтай, оролцоо сайтай оролцохоос гадна нэр дэвшигчээс сайн асуултууд асуухаас гадна олон нийт хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй яг тэгж байж нөгөө нийгэм бас энэ сонсголтой чинь сайн танилцах ёстой байхгүй юу. Тэгээд маргааш өглөө 9 цаг гэхэд тэгээд тэр бэлтгэл ажил чинь ер нь хэр хангагдаж байгаа юм бэ?

Б.Заяабал: Байнгын хорооны ахлах зөвлөх Мягмарцэрэн Яг дэгтэй холбоотой бүх асуудлыг хуулийн үндэслэлээр нь тайлбар даруулаах даа.

Д.Мягмарцэрэн: Дэгийн тухай хуулийн 131.1-д заасны дагуу Байнгын хороо энэ хуулийн 130.1, 130.2-т заасан ажиллагааг явуулснаас хойш 14-өөс доошгүй

хоногийн хугацаанд нэр дэвшигчээс асуух асуулт, саналыг цахимаар, эс үгүй бол шуудангаар хүлээн авах бөгөөд нэр хаяггүй асуулт, саналыг бүртгэхгүй, асуулт, санал хүлээн авах хугацааг Байнгын хороо тогтоох шаардлагатай бол тухайн сонсголын дэгийг боловсруулж батлах зэрэг сонсголын бэлтгэлийг хангана гэж заасан байгаа. Энэ дагуу түрүүчийн долоо хоногт бол 16 гишүүний ирүүлсэн албан бичгийг гишүүддээ тараасан байж байгаа.

06 сарын 09-ний өдрөөс эхлээд parliament.mn сайтад сонсголын бэлтгэл хангаад, нөгөө тов зарлагдаад, тэгээд бүх зар мэдээлэл тавиад нийтдээ 15 оролцогч оролцохоор саналаа ирүүлснээс 7 оролцогч, тийм 7 оролцогч асуултаа урьдчилан ирүүлээд ингээд сонсголын бүх бэлтгэл бол хангагдсан байж байгаа.

Б.Заяабал: Жавхлан гишүүн. Жавхлан гишүүн асуултаа татлаа. Гишүүд асуулт асууж, санал хэлж дууслаа.

Одоо бүгдээрээ санал хураалт явуулъя. Саналын томъёолол “Нэр дэвшигчийн сонсголын товыг тогтоох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Гишүүдийг санал хураалтдаа бэлдэхийг хүсье. Саналын томъёоллоо уншсан байгаа. Тэгээд саналын томъёоллын дагуу дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

95.2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ. Дараагийн асуудалдаа оръё.

14.19 цаг.

Дараагийн асуудал хэлэлцэх асуудал 2 дээр энэ Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэхээр байгаа.

Тийм, тэгээд Хууль санаачлагч бас өнөөдөр Үндэсний аюулгүй байдлын зөвлөл хуралдаж байгаа тэнд бас мэдээлэл өгч байгаа юм байна. Ийм учраас хойшлуулаад гурав дахь асуудлыгаа хэлэлцээд явъя.

Гурав дахь асуудал. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Энэ хуулийн ажлын хэсгийг оруулъя. Хуулийн төслийн талаарх төсөл санаачлагчийн танилцуулгыг Монгол Улсын Их Хурлын гишүүн Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн танилцуулна. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн. Ажлын хэсгийг оруулъя.

Хуулийн төслийн талаарх төсөл санаачлагчийн танилцуулгыг Их Хурлын гишүүн, Их Хурлын дэд дарга Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн танилцуулна. Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг нээе.

Ж.Бат-Эрдэнэ: Эдийн засгийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн М.Мандахаа нараас 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийн тогтвортой хөдөө аж ахуй гэсэн 12 дугаар зүйл тогтвортой хөдөө

аж ахуйг хөгжүүлэх зорилгоор улсын хэмжээнд дунд хугацааны хөгжлийн зорилтот хөтөлбөртэй байхаар тусгаж өргөн мэдүүлсэн.

Дээрх зохицуулалттай нийцүүлж Хөдөө аж ахуйн тухай хуулийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгээс Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах гэсэн саналыг гаргасан бөгөөд уг санал нь Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны болон нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн болно.

Иймээс Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.5 дахь хэсэгт анхдагч болон хуулийн шинэчилсэн найруулгын төслийн анхны хэлэлцүүлгээр санал хурааж шийдвэрлэсэн зарчмын зөрүүтэй саналтай холбогдуулан Байнгын хороо төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхдээ хууль тогтоомжийн хоорондын уялдааг хангах зорилгоор холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан хамтад нь хэлэлцүүлж болно гэж, 42 дугаар зүйлийн 42.6 дахь хэсэгт энэ хуулийн 42-т заасан төсөл нь бусад Байнгын хорооны эрхлэх асуудал хамааралтай бол тухайн Байнгын хороо уг төслийг хэлэлцэж, санал, дүгнэлтээ холбогдох Байнгын хороонд хүргэнэ гэж заасантай нийцүүлж Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг санаачлан боловсрууллаа.

Хуулийн төсөл 2 зүйлтэй. Төслийн 1 дүгээр зүйл. Төслийн хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгийн төрөл гэсэн 6 дугаар зүйлийн 6.5-д хэсэгт хөдөө аж ахуйн хөгжлийн зорилтот хөтөлбөр гэж 6.5.9 дэх заалт нэмэх, төслийн 2 дугаар зүйлд тус хуулийг Хөдөө аж ахуйн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөх зориулалтаар тусгасан болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос боловсруулсан хуулийн төслийг хэлэлцэж шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Заяабал: Баярлалаа. Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсгийг баримтлан хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ.

Хэлэлцүүлгийн явцад 39 дүгээр зүйлийн 39.11 дэх хэсэгт заасны дагуу гишүүд тухайн зүйлтэй холбогдуулан асуулт асуух боломжтой. Ингээд асуулт асуух, санал гаргах гишүүд байвал нэрсээ өгье өө.

Анар гишүүнээр тасаллаа. Анар гишүүний микрофоныг олгоё.

Ч.Анар: Сайн байцгаана уу? Энэ ажлын хэсгээс асууя. Энэ Хөдөө аж ахуйн хууль дагаж орж ирж байхдаа жижиг нэр томьёоны өөрчлөлт юм уу, уялдуулж байгаа өөрчлөлт юм уу, эсвэл том реформын шинж чанартай, том бодлогын

баримт бичиг болох юм уу? Хэрвээ тийм бол энэ баримт бичгийг дагаж орж ирэх санхүүжилтийн эх үүсвэр, Ки Пи Ай, хариуцах институцийн талаарх хуулийн төсөлд орж ирсэн байгаа юу? Яаж орж ирсэн байгаа вэ?

Энийг яагаад асуугаад байгаа юм бэ гэхээрээ баахан ийм бодлого төлөв баримт бичгүүд бид нар гаргаад байдаг. Энэ дээр чинь 6.5.1-ээс өгсүүлээд Эдийн засгийн хөгжлийн зорилтот хөтөлбөр, Дэд бүтцийн зорилтот хөгжил, хөтөлбөр, бүсийн өрсөлдөх чадварын гээд байгаа эд нартайгаа хариуцаж байгаа институц болоод чиг үүргийн хувьд давхцаад байгаа харагдаж байгаа юм. Тэгэхээр энийг яаж зохицуулах вэ гэдэг асуулт асууя.

Б.Заяабал: Ажлын хэсэг Бат-Эрдэнэ даргын микрофон өгье.

Ж.Бат-Эрдэнэ: Ер нь Мандхай гишүүний Хөдөө аж ахуйн тухай хуулийг хэрэгжүүлэх явц, боловсруулах тэгээд цаашаа бол ажлын хэсэг дээр бид нар ярьж байгаад ер нь хөдөө аж ахуйн бодлого бол бас ер нь тасраад байгаа юм. Орон нутгийн хэмжээнд ч тэр, нийт бодлогын хэмжээнд ч тэр яамнаас гаргаж байгаа бодлогын хүрээнд ч тэр яг нэгдсэн ийм бодлого бол нэгдүгээрт бол гарч ирэхгүй байгаа болчихоод байгаа юм.

Хоёрдугаарт Хөдөө аж ахуйн хуулийн хамгийн гол зорилго бол бид нар бол хөдөө аж ахуйгаа нэлээн эрчимжүүлэх, сайжруулах, хөгжүүлэх, тэгээд үйлдвэрлэлийн тогтолцоо, тэр нэмүү өртөг шингэсэн байх эд нар гээд нэлээн том өөрчлөлтүүдийг хийхгүй бол болохгүй болчихоод байгаа юм.

Тэгэхээр энд тодорхой бод бодлого байж байж энэ бодлого нь энэ тодорхой хуулиуд дээр шингэж өгөхгүй бол энэ цаашаа бол зүгээр цаасан дээр үлдсэн ийм хууль болж хувирчих гээд байгаа юм. Яг амьдрал дээр. Ингээд харахад бол Хөдөө аж ахуйн яамнаас гаргаж байгаа бодлого, хөдөө аж ахуйн бодлого гэдэг зүйл маань бол тодорхойлсон бодлого байх. 3, 4 жилээр бид нар зүгээр тухайн сайд ямар бодлого гаргаж байна тэр нь л ерөнхийдөө орон нутаг руу хагас дутуу очоод байгаа болохоос биш үндсэн концепцынхоо хүрээнд бол хөдөө аж ахуйн бодлого гэсэн зүйлийг бол бид нар зайлшгүй гаргаж өгөхгүй бол болохгүй болчихоод байгаа юм.

Ерөнхийдөө бол эдийн засаг гэдэг рүүгээ давхар орчихоод байгаа болохоос биш хөдөө аж ахуй маань үндсэндээ бол хаягдчихаад байгаа юм. Одоо бид нар Монгол Улсын хэмжээнд хөдөө аж ахуйн бодлогоо, газар тариалангийн бодлогоо, мал аж ахуйн бодлогоо бол нэлээн өндөр түвшинд гаргаж ирэхгүй бол болохгүй болчихоод байна шүү дээ. Дагалдах үндсэндээ бол мал аж ахуй гэдэг бол мал аж ахуй, хөдөө аж ахуй гэдэг бол уул уурхайнхаа ар дээр орох ёстой бодлогын хүрээнд бол бид нар дэмжих ёстой эдийн засгийн нэлээн том хүчин зүйл гэж харж байгаа мөртөөрөө энэ нь дагалдсан байдлаар нэгдүгээрт яваад байна.

Хоёрдугаарт эдийн засагт үнэхээр том бодлого нь бол орж чадахгүй байгаа тул ингээд Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн удирдлагын тухай хуульдаа бол яг хөдөө аж ахуйгаа нэг мөр бол дагнаад хөдөө ахуйнхаа том бодлогыг бол суулгая гэсэн ийм бодлогоор л ажлын хэсэг оруулж ирж байгаа. Мандах одоо.

Б.Заяабал: Хууль санаачлагч гишүүн Мандхай гишүүний микрофоныг өгье. Нэмэлт тодруулга өгнө.

М.Мандхай: Бат-Эрдэнэ даргын хэлсэнтэй нэмээд хэлэхэд одоо ер нь бол манай Засгийн газар солигдох бүрд улсын энэ тэргүүлэх чиглэл, төсөв байгууллагын бүтэц ер нь өөрчлөгддөг. Энэ хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн үр дүнг бид нар 1-4 жилээр хэмжиж бол болохгүй юм байгаа юм. Тэгэхээр энэ 10-аас өөрөө 20 жилийн дараа гардаг ийм онцлогтой улирлын ийм хамааралтай салбар.

Тийм учраас олон улсын жишгээр бол угаасаа мөн адилхан хөдөө аж ахуйн бодлогоо 10-20 жилээр хэмжиж гарч байгаа. Нидерланд, Шинэ Зеланд, Канад гээд Хятад бүх улс орнууд ингэж явж ирсэн. Тэгээд өнөөдөр манай хөдөө аж ахуйн салбар ер нь хөгжихгүй, маш их хэмжээний татаас, урамшуулал, төсөв нэмэгддэг ч гэсэн ингээд нэмэгдэхгүй байгаад байгаа нь шууд бас энэ ерөнхийдөө урт хугацааны бодлого байхгүй хэрэгжиж ирсэнтэй холбоотой юм байгаа юм.

Тийм учраас энэ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах энэ хуулийн төслийг.../минут дуусав./

Б.Заяабал: Мандхай гишүүний микрофоныг нэмж өгье.

М.Мандхай: Тэгээд энэ 10 жилийн гол энэ хөдөө аж ахуйн зорилтот хөтөлбөрийг 10 жилийн бодлого боловсруулах шаардлага үндэс нь нэгдүгээрт энэ үйлдвэрлэл урт хугацаанд үр дүн гардаг учраас энийг энэ урт хугацаанд нэгд барих хэрэгтэй. Ингэж байж бид нар үр дүн, бүтээмжийг ийм хэмжих боломжтой байгаа.

Хоёрт энэ уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийг бууруулахад шууд хамааралтай.

Гуравд энэ хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангахад зайлшгүй энэ бас урт хугацааны бид нарт бодлоготой явахгүй бол болохгүй.

Дөрөвдүгээрт энэ хөрөнгө оруулалтын тогтвортой орчныг бүрдүүлэх хэрэгтэй байгаа юм. Тэгэхээр энэ засгийн энэ юм уу сонгуулийн мөчлөгийг дагаж энэ бодлого, тэргүүлэх чиглэлийг хөдөө аж ахуйтай уялдуулж тоглохоор хөрөнгө оруулалт, тогтвортой хөрөнгө оруулалтыг татах, дээрээс нь энэ урт хугацааны бид нар энэ бодлогоо хэрэгжүүлэх ийм үндэслэл байхгүй болчихоод байгаа юм. Тийм учраас хөдөө аж ахуйн салбарыг мэдээж эдийн засгийн гол тулгуур салбар болгож хөгжүүлэх, уул уурхайгаас ангид салбар.../минут дуусав./

Б.Заяабал: Гишүүд асуулт асууж дууслаа.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдээс зарчмын зөрүүтэй санал ирүүлээгүй байна.

Ингээд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд Мандхай гишүүн танилцуулчих уу? Мандхай гишүүн танилцуулна.

Хоёр дахь асуудалдаа оръё. Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийгээ явуулъя.

Ажлын хэсгийг танилцуулъя. Анхны хэлэлцүүлэг учраас танилцуулга хийхгүй шууд ажлын хэсгийг танилцуулаад явъя.

Хишигдалай Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга, Мөнх-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Төгөлдөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Маргад Ашигт малтмал, газрын тосны газрын Газрын тосны ашиглалтын хэлтсийн дарга, Төгсжаргал Татварын Ерөнхий газрын Том татвар төлөгчийн газрын дарга гэсэн ажлын хэсгийн гишүүд хүрэлцэн ирсэн байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт хэсгийг баримтална.

Хуулийн төслүүдийг зүйл бүрээр бас хэлэлцэнэ. Хэлэлцүүлгийн явцад 39 дүгээр зүйлийн 39.11 дэх хэсэгт заасны дагуу гишүүд тухайн зүйлтэй холбогдуулан хууль санаачлагчаас болон бусад оролцогчоос асуулт асуух боломжтой.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс бичгээр ирүүлсэн саналаар санал хураалт явуулъя. Саналын томъёоллыг уншиж танилцуулъя. Саналын томъёоллыг байна уу?

Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд, Бямбасүрэн, Бадамсүрэн, Сэддорж нарын гишүүдээс санал ирүүлсэн байгаа. Ингээд саналын томъёоллыг уншиж танилцуулъя.

Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлийн “5 хувиар” гэснийг “7.5 хувиар” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд, Бямбасүрэн, Бадамсүрэн, Сэддорж гэсэн байна. Нэг л санал хураалт байгаа юм байна. Санал гаргасантайгаа холбоотой санал гаргасан гишүүн Соронзонболд гишүүн тайлбар хэлнэ. Соронзонболд гишүүнд микрофон олгоё.

Л.Соронзонболд: Эдийн засгийн байнгын хорооныхоо эрхэм гишүүдийн энэ өдрийн амрыг эрье. Тэгэхээр энэ манай Дорнод аймагт байгаа энэ 2 газрын тосны талбай маань 19 дүгээр талбай, 21 дүгээр талбай гэж байгаа. 19 дүгээр талбай нь болохоор бол 1991 оны тухайн үед мөрдөгдөж байсан хуулийн дагуу Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулагдсан юм. Тэгээд тэр үеийн Бүтээгдэхүүн хуваах гэрээн дээр бол энэ газрын тосны нөөц ашиглалтын төлбөрийн тухай асуудал байдаггүй байсан. Тэгээд ямар ч байсан Засгийн газраас орж ирж байгаа энэ саналыг бол дэмжиж байгаа.

Өөрөөр хэлбэл, ямар ч байсан энэ Тосон уул, 19 дүгээр талбай дээр 5 хувийн газрын тосны үйлчилгээний төлбөр авдаг больё гэдэг ийм санал орж ирж байгаа.

Тэгэхээр зүүн бүсээс сонгогдсон тэр дундаа Дорнод аймгаас сонгогдсон гишүүдийн хувьд бол Бадамсүрэн гишүүн, Бямбасүрэн гишүүн, мөн манай говийн бүсээс Сэддорж гишүүн бид 4 болохоор бол энэ 2 талбайн хувьд бол ялгаа байхгүй юм байна. 21 дүгээр талбай нь бол 7.5 хувийн газрын тосны нөөц ашигласны төлбөрийн тогтоогдсон.

Харин 19 дүгээр талбай буюу Тосон уул талбай дээр нь 5 хувь гэж байгааг яг мөн адилхан 21 дүгээр талбайд адилхан 7.5 хувь болгоё гэж байгаа юм. Энэ дээр болохоор бол цаад тэр компаниас төлж байгаа төлбөр дээр бол ямар нэгэн нэмэгдэж байгаа зүйл байхгүй. Яагаад гэхээр тухайн компани маань Бүтээгдэхүүн хуваах гэрээнийхээ дагуу бол төлбөрөө төлдгөө амлана. Тэндээс Монгол Улсын Засгийн газар төсвийн орлогод авдаг хэсгээсээ болохоор бол газрын тосны нөөц ашигласны төлбөрт хуваарилаад тэндээс Орон нутгийн хөгжлийн сан руу хуваарилагдаж байгаа хэсэг дээр л бага хэмжээний нэмэлт гарна.

Ойролцоо тооцооллоор бодоод үзэхээр бодоод үзэхээр энэ өнгөрсөн жилүүдийг харахаар ойролцоогоор 200 гаруй сая төгрөг л нэмэгдэхээр ийм гарч ирж байна лээ. Энэ Орон нутгийн хөгжлийн сан руу хуваарилагдах хэсэг нь. Тэгэхээр энэ дээр та бүхнийг, Эдийн засгийн байнгын хорооны гишүүдийг дэмжиж өгөхийг хүсье.

Б.Заяабал: Гишүүд санал гаргасан гишүүний нэмэлт тайлбарыг сонслоо. Одоо Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагаж хамт өргөн мэдүүлэхээр орж ирсэн Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйл саяын гишүүдийн гаргасан санал байгаа. 3 дугаар зүйлтэй холбоотой асуулт асуух гишүүд байвал бас нэрсээ өгье.

Алга байна.

Хуулийн төслүүдийг зарчмын зөрүүтэй саналаар санал хураалтыг явуулъя. Гишүүдийг санал хураалтдаа бэлдэхийг хүсье.

Саналын томьёолол Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлийн “5 хувиар” гэснийг “7.5 хувиар” өөрчлөх гэсэн. Гишүүд Соронзонболд, Бямбасүрэн, Бадамсүрэн, Сэддорж нарын гишүүдийн саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

66.7 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд танилцуулах уу? Соронзонболд гишүүн танилцуулна.

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж байна. Хуралдаан үүгээр өндөрлөж байгааг мэдэгдье. Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

14.38 цаг.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР